



Залуучуудын Хөгжлийн
Хөтөлбөр
(2013-2017)



**Залуучуудын хөгжлийн тулгамдсан асуудлаарх бодлогын түвшний,
нотолгоонд суурилсан Нөлөөллийн хөтөлбөр,
Стратеги боловсруулах Зөвлөх үйлчилгээний удирдамж**

Үндэслэл: Иргэний Боловсролын Төв нь НҮБ-ын Хүн амын сангийн улс орныг дэмжих Тавдугаар хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэгч хамтрагч байгууллагаар сонгогдон ажиллаж байна.

Монгол улсын хүн амын 38,5%-ийг эзэлж буй залуучуудын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого байхгүй, залуучуудын дийлэнх нь өөрсдийн асуудлаар шийдвэр гаргах түвшинд нөлөөлөл хийх чадвар, туршлага дутмаг байна. ХАХНХЯ-аас санаачлан залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, “Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөр боловсруулан 2015 онд багтаан батлуулахаар төлөвлөсөн боловч Хөгжлийн бодлогын шинэ хууль гарсантай холбоотойгоор хойшилогдоод байна. Зарим аймаг, сумд орон нутгийн түвшинд залуучуудын талаар баримтлах төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж буй туршлага бий боловч түүний хэрэгжүүлэлтийг хянах, сайжруулах, илүү олон аймаг сумдыг залуучуудын талаар тусгай хөтөлбөр, төсөлтэй болгох, орон нутагт залуучуудын бодит оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ байна. Залуучуудын бодит оролцоог залуучуудын эрх ашигт нөлөөлж буй аливаа асуудлаар гарах бодлого шийдвэрт хангах, залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэх зорилгын хүрээнд бодлогын түвшний нөлөөллийн ажлыг төлөвлөж, хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 онд тавигдаж буй бодлогын нөлөөллийн зорилтуудын хүрээнд нөлөөллийн хөтөлбөр, стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөг боловсруулах нь нэн шаардлагатай байна.

Зөвлөх үйлчилгээний Зорилго: Шинээр боловсруулж буй Залуучуудын асуудлаар төрөөс баримтлах бодлого, “Монгол Залуу хүн” Үндэсний хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газарт өргөн барьж, батлуулахын тулд залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн шийдлийг бодлого, шийдвэр гаргагчдад таниулах бодлогын түвшний, нотолгоонд суурилсан нөлөөллийн хөтөлбөр, арга зүй, төлөвлөгөөг боловсруулж залуучуудын нийгмийн олон янзат бүлгүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргагчид болон олон нийтэд залуучуудын, ялангуяа зорилтот бүлгийн дуу хоолойг хүргэх,

бусдын анхаарлыг татаж дэмжүүлэх, бодлого стратеги, төлөвлөгөө боловсруулахад оршино.

Хугацаа: 2016 оны 2 сарын 18 - 2016 оны 3 сарын 18 буюу нийтдээ 22 хоног, үүнээс 7-с доошгүй хүн-хоногийг хэрэгжүүлэх шатанд буюу зохих түвшний уулзалт, сургалтанд оролцох, зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

Зөвлөхд тавигдах шаардлага:

- Монгол улсын иргэн байх
- Судалгаа мэдээлэл цуглуулахад шаардлагатай англи хэл болон аль нэг гадаад хэлний өндөр мэдлэгтэй, тайланг монгол хэл дээр, тайлангийн товчийг англи, монгол хэл дээр бичиж өгнө.
- Нийгмийн ухаан, менежмент, маркетинг, хууль болон бусад холбогдох чиглэлээр дотоод гадаадын их дээд сургууль төгссөн, магистр буюу адилтгах түвшний туршлагатай байна.
- Судалгаа шинжилгээний болон нотолгоонд суурилсан бодлогын түвшний нөлөөлийн ажил хийсэн 3-аас доошгүй жилийн дадлага туршлагатай,
- Нам улс төрийн хүчний болон салбарын хэмжээний бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын талаар ойлголт мэдлэг, туршлагатай,
- Төлөвлөлт, дүн шинжилгээ, үнэлгээ хийх чадвар, туршлагатай.
- Гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагаа цаг тухайд нь чанартай хийж гүйцэтгэдэг
- Багаар ажиллах чадвартай

Зөвлөхийн гүйцэтгэх ажил:

1. Залуучуудын хөгжлийн асуудлаарх Монголын болон олон улсын бодлогын түвшний нөлөөллийн сайн туршлагыг судлах,
2. Залуучуудын асуудлаарх сүүлийн үеийн судалгаа, тоо мэдээлэл, нотолгоотой танилцаж, залуучуудын асуудлууд, тэдгээрийн шийдлийг томъёолсон байдлыг нэгтгэн дүгнэх,
3. Монгол улсын төрөөс Залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлого, “Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөрийн төслийг судалж, дүн шинжилгээ хийх,
4. Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас Залуучуудын хөгжлийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлсэн байдлыг судлах,
5. Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын асуудлыг тусгах, улсын болон орон нутгийн төсөвт зардлыг нь байршуулах боломжийг судлах ,

6. Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, Залуучуудын Хөгжлийн төвүүдийн хийсэн нөлөөллийн ажлын байдлыг судлах,

Дээрх судалгаа шинжилгээний ажлын үндсэн дээр:

- Залуучуудын асуудлаар Төрөөс баримтлах бодлого, “Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөрийг Засгийн газарт өргөн барьж батлуулахад шийдвэр гаргагчид болон олон нийтэд нөлөөлөх, залуучуудын дуу хоолойг хүргэх, оролцоог нэмэгдүүлэх бодлогын түвшний, нотолгоонд суурилсан нөлөөллийн хөтөлбөр, стратеги, төлөвлөгөөг боловсруулах
- Залуучуудын ТББ, ЗХТ –ийн нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөө, аргачлалыг боловсруулах,
- Хийсэн ажлын дагуу дүн шинжилгээ, санал зөвлөмж бүхий ажлын тайланг бэлдэх зэргийг гүйцэтгэнэ.